



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 4/08

Баянтал сум

2023 оны сургалтын төлөвлөгөөг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор 2023 оны сургалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтанд албан хаагчдаа бүрэн хамруулах, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.

3. Сургалтын хэрэгжилтэнд хяналт тавьж хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Хууль эрхзүй хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ДАРГА



В.ГАНТУЯА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГИН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 4/09

Баянтал сум


Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн үйлчилгээний албан хаагчдын сарын ажлыг дүгнэж, зохих үнэлгээ авсан тул ур чадварын нэмэгдлийг хавсралт ёсоор олгосугай.

2. Ур чадварын нэмэгдлийг төсвөөс гаргахыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



В.ГАНТУЯА

Засаг даргын Тамгын газрын даргын  
2023 оны 01 -р сарын 23-ны өдрийн  
А/25 тушаалын хавсралт

**Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний  
албан хаагч нарын сарын ажлын үнэлгээ**

2023 оны 04 сарын 24-ны өдөр

Лүн

Д/д	Овог нэр	Шалгуур үзүүлэлт				
		Ёс зүй, харилцаа, хандлага	Мэдээ, тайлан /шилэн данс/ гаргах, үүрэг даалгаврын биелэлт	Ажлын цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, бүтээлч хандлага	Нийт оноо	Нийт хувь
1	Х.Ариунгуа	15	5	5	25	25
2	Н.Сарантуяа	15	5	5	25	25
3	Ц.Болдбаатар	15	5	5	25	25
4	Б.Наранцэцэг	15	5	5	25	25
5	Б.Оюунцэцэг	15	5	5	25	25
6	Н.Мөнгөнцэцэг	15	2	5	22	22
7	Б.Солонгома	-	-	-	-	-

**Жич: Бүх үзүүлэлтүүдийг 5-15 оноогоор дүгнэнэ. Сахилгын шийтгэлтэй, ээлжийн амралттай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй.**